

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжих эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Төрийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Цагдаагийн өрөнхий газар

Удирдлага

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Тэргүүн дэд дарга

ТТ-1

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр
хороо Самбуутийн гудамж 18

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс, Үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл
баримтлал, Монгол Улсын хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтнаас
гаргасан тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, хууль сахиулах чиглэлээр
баримтлах бодлого, үндсэн чиглэл, ойрын болон хэтийн зорилтыг тодорхойлох, хуулиар
хүлээсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах, дэмжлэг
үзүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, гэмт
хэргээс урьдчилан сэргийлэх, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, гэрч, хохирогчийг
хамгаалах, техник, технологи, харилцаа холбооны чиглэлээр алба, нэгж, нутаг дэвсгэр
хариуцсан цагдаагийн байгууллагын уялдаа холбоог хангах, үүрэг, чиглэл, зөвлөмж өгөх
чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг байгууллагын даргын өмнө хариуцахад
оршино.

Албан тушаалын зорилт:

1. Цагдаагийн албаны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах ажилд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, бодлого стратегийг боловсруулж хэрэгжүүлэх;
2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад мэргэжил, арга зүйгээр хангах, зөвлөх;
3. Эрхлэх асуудлын хүрээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах, санал танилцуулах.

| | | | |
|---------------------------|--|---|---|
| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах – Т, Хариуцан гүйцэтгэх – Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш |
| 1 дүгээр зорилтын хүрээнд | <p>1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан зарлиг, тогтоол, тушаал, хөтөлбөр, төсөл, журмыг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөх;</p> <p>2. Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, цагдаагийн хүрээний дүрэм, Эргүүл, харуулын дүрэм болон албаны үйл ажиллагаанд дагаж мөрдөх бусад дүрэм, журам, зааврыг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгож, мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>3. Гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд албадыг удирдан зохион байгуулж, удирдлагыг мэдээллээр хангах;</p> <p>4. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх хэтийн болон дунд хугацааны стратеги зорилго, зорилтыг тодорхойлох;</p> <p>5. Хэтийн зорилго, зорилттой уялдуулан тухайн жилийн үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжилтийг хангуулах;</p> <p>6. Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ бусад байгууллагуудтай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах;</p> | Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бодлогын хэрэгжилт хангагдсан байна. | Х, Г, Ш |

| | | | |
|---------------------------|--|--|---------|
| | <p>7.Шүүх, прокурорын байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, даалгавар, шаардлагын мөрөөр тодорхой арга хэмжээ авч, үүрэг, ажлын чиглэл өгч, биелэлтийг хангуулах;</p> <p>8.Бүртгэгдэх үедээ сэжигтийн зооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэх ажлыг гүйцэтгэх ажилтай уялдуулан зохион байгуулах, үр дүнг тооцох;</p> <p>9.Гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, биелэлт үр дүнг тооцох.</p> | | |
| 2 дугаар зорилтын хүрээнд | <p>1.Мэдээллийг нэгтгэн боловсруулах, судалгаа, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, удирдлагын үйл ажиллагаанд шаардлагатай санал дүгнэлт, зөвлөмж, шийдвэрийг боловсруулж, танилцуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үр дүнг тооцох;</p> <p>2.Цагдаагийн байгууллагын техник, технологи, холбооны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, нэвтрүүлэх, хөгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үр дүнг тооцох;</p> <p>3.Цагдаагийн тусгай дугаарын утсанд иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, эрэн сурвалжлах, зарлан мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үр дүнг тооцох;</p> <p>4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үр дүнг тооцох;</p> <p>5.Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил арга зүйн</p> | <p>Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.</p> | X, Г, Ш |

| | | | |
|---------------------------|--|--|--------|
| | удирдлагаар хангах, үр дүнг тооцох. | | |
| 3 дугаар зорилтын хүрээнд | <p>1. Монгол Улсын хууль, Еренхийлэгчийн зарлиг, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих;</p> <p>2. Эрхэлсэн асуудлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах;</p> <p>3. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах/-ыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;</p> <p>4. Цагдаагийн ерөнхий газрын даргаас тусгайлан хариуцуулсан үүрэг, чиглэлийг хэрэгжүүлж, үр дүнг тооцох;</p> <p>5. Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрээр ахлан ажиллах орон тооны бус зөвлөл, комисс, ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, дүнг танилцуулах;</p> <p>6. Цагдаагийн ерөнхий газрын даргын эзгүйд албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх, халах болсон тесөв захиран зарцуулахаас бусад бүрэн эрхийг хэрэгжүүлж, түр орлон гүйцэтгэх;</p> <p>7. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;</p> <p>8. Авлига, хүнд суртлаас анgid байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд сахих;</p> <p>9. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах.</p> | Холбогдох албан тушаалтнууд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангагдсан байна. | X, Г Ш |

ШААРДЛАГААЛСАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | |
|-----------|--|
| Боловсрол | - магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. |
| Мэргэжил | - Эрх зүй (0421) |
| Мэргэшил | - Төрийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байх. |
| Туршлага | - Цагдаагийн албанад 15-аас доошгүй жил ажилласан, нийтийн хэв журам хамгаалах, гүйцэтгэх болон мөрдөн |

| | | |
|-----------|--------------------------|--|
| | | байцаах ажлын дадлага туршлагатай, улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй байх. |
| | Удирдан зохион байгуулах | <ul style="list-style-type: none"> - байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх; - байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; - байгууллагын албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй хуваарилах; - албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих, мэдлэг, туршлага, ур чадварыг ашиглах; - саналын зөрүү, үйл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - албан хаагчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэлийн зөрүүг арилгахад туслах, зөвлөх, чиглүүлэх, шаардлага тавих; - бусад. |
| | Дүн шинжилгээ хийх | <ul style="list-style-type: none"> - мэдээлэлд тулгуурлан бүтэц, чиг үүргийн болон системийн шинжилгээ хийх; - хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд санал, зөвлөмж өгөх; - судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын шууд ба шууд бус үр дагаврыг харьцуулан үнэлэх; - бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | <ul style="list-style-type: none"> - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - хууль тогтоомжийн тэсөлд санал өгөх; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - бусад. |
| Үр чадвар | Манлайлах | <ul style="list-style-type: none"> - ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байдлаар үлгэрлэх; - байгууллагын үйл ажиллагаанд шинэлэг санаа, ажил үйлчилгээг нэвтрүүлэх, алба хаагчдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олонд тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - байгууллагын стратеги зорилтыг тодорхойлоходоо хамт олны саналыг сонсох, тусгах, өөрчлөлтийг хийхдээ урьдчилан тооцоолж, манлайлан удирдах; - бусад. |
| | Бусад | <ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг, хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, харилцааг бий болгох, харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглах; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг бүрдүүлэн ажилладаг байх; - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах; |

| | |
|--|---|
| | <ul style="list-style-type: none"> - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх чадвартай байх; - албан тушаалын чиг үүргээ аливаа нөхцөлд хэрэгжүүлэх чадвартай байх; - төрийн архив, албан хэрэг хетлөлтийн мэдлэгтэй, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх; - мэргэжлээрээ ажилласан туршлагатай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; - авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих. |
|--|---|

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга.

| | |
|---|---|
| <p>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүгийн цагдаагийн алба; - Мөрдөн байцаах алба; - Экологийн цагдаагийн алба; - Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба; - Хар тамхитай тэмцэх газар; - Урьдчилан сэргийлэх газар; - Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс; - Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн дарга нар; - Бусад. | <p><u>Бусад харилцах субъект</u></p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын ерөнхийлөгчийн Тамгын газар; - Улсын Их Хурлын Тамгын газар; - Засгийн газрын Хэрэг эрхлэх газар; - Хууль зүй, дотоод хэргийн сайд, Дэд сайд; - Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга; - Төрийн албаны зөвлөл; - Бүх шатны шүүх, прокурорын байгууллага; - Нийслэл болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага; - Төрийн болон төрийн бус байгууллага; - Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага. |
|---|---|

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧЛ.НЯМГЭРЭЛ

(Гарын үсэг) (Эцэг/эх-/ийн нэр,
өөрийн нэр)
2024 оны 01 дугаар сарын 08-ны өдөр

Байгууллагын нэр:

VI.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

Байгууллагын нэр:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо:

Дугаар:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

(Рарын усэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)
2024 оны 08 дугаар сарын 08-ны өдөр

Б.ЭНХБАЯР

---оо---